

21.1. ЭЕШ давтлага хичээл бүртгэх

21.1. ЭЕШ давтлага хичээл бүртгэх

ЭЕШ-д бэлтгэх давтлага хичээлийн бүртгэлийг системд хийхдээ дараах дараалалыг баримтлана. Үүнд:

1. Давтлага хичээл орох багшийн заадаг хичээлд давтлага хичээлийг үүсгэж өгөх
2. “Хичээлийн бүлэг”-ээр ээлжит хичээл үүсгэж баталгаажуулах
3. Хичээл сонголтоор суралцагчийг сонгож бүртгэнэ.
4. Ирц бүртгэнэ.

Системд хэрхэн оруулах алхамчилсан дараалал:

1. Багшийн заадаг хичээл оруулах

Сургалтын менежер **Боловсролын удирдлагын системийн Багш** үйл ажиллагаа руу орж багшийн нэрийн жагсаалтаас тухайн багшийг сонгож нэр дээр дарж орсноор багшийн мэдээллийн дараах цонх руу шилжинэ.

Баруун дээд хэсэгт байрлах **мэдээлэл засах** товчийг дарж орно. **+Хичээл нэмэх** товчийг дарснаар заадаг хичээлийг оруулах мөр гарч ирнэ. ЭЕШ давтлага хичээлийн судлагдахуун, хичээлийг сонгож хадгална. Дараах хүснэгтээс сонгох судлагдахуун, хичээлийг харж зөв сонгоно уу.<